

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН  
2021 ОНЫ 05 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 06 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн хувийн урилга, виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 1416 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгосноос 1326 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт, 90 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомтод тус тус илгээлээ.

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 249 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын Монгол Улсын визийг олгож, 3 иргэнд визийн шилжүүлэг хийсэн. /Хүснэгт 1/

2021 оны дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 82,4 хувь, виз олголт 60,2 хувиар өсөж, оршин суух зөвшөөрөл хасалт 70.8 хувь, виз сунгалт 87.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 611 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 1501 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 245 иргэний бүртгэлд хасалт хийсэн. /Хүснэгт 1/


Тайлант хугацаанд нийт 133 аж ахуйн нэгж, байгууллагын 328 гадаадын иргэний хүсэлтийг цахим /e-visa.mn/-аар хүлээн авч, шийдвэрлэсэн байна. Үүнд:

- “Т” ангиллын 76 аж ахуйн нэгж, байгууллагын 89 гадаадын иргэн,
- “НГ” ангиллын 34 аж ахуйн нэгж, байгууллагын 140 гадаадын иргэн,
- “S” ангиллын 1 аж ахуйн нэгж, байгууллагын 1 гадаадын иргэн,
- хувийн хэргээр оршин суугч 29 гадаадын иргэн,
- түр ирэгчээр визийн байх хугацааг сунгуулах 18 гадаадын иргэний хүсэлт,
- визийн зөвшөөрөл хүссэн 22 аж ахуйн нэгж, байгууллагын 51 гадаадын иргэний хүсэлт (“А” ангиллын 8, “В” ангиллын 15, “О” ангиллын 2, “Т” ангиллын 26 гадаадын иргэнд нэг болон хоёр удаагийн орох)-ийг холбогдох хууль, журмын дагуу тус тус хянан шийдвэрлэжээ.

Мөн оршин суугаа хэлбэр нь өөрчлөгдсөн 29 гадаадын иргэнд визийн ангилал солих үйлчилгээ үзүүлж, уригч 33 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу гадаадын 77 иргэний виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгосон байна.

Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 394 гадаадын иргэнийг бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн 214 иргэний бүртгэлд хасалт хийж, Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн, мөн визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэнээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 66 иргэний визийн хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж, гадаадын 3 иргэнд регистрийн дугаар олгосон. /Хүснэгт 1/

Хүснэгт 1



Монгол Улсад оршин суух цахим үнэмлэхийг 911 ширхэг шинээр хэвлэн, 1023 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 159 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний өөрчлөлт хийлээ.

## 1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

### 1.2.1. Монгол Улсын харьяат болох, гарах, сэргээн тогтоолгох:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын 4 иргэн (*Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 4*)-ний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авч, мөн хүсэлт гаргасан гадаадын 5 иргэн (*Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 4, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын 1*)-ний хүсэлтэд санал авахаар холбогдох байгууллагуудад хүргүүлэн, Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй гадаадын 1 иргэн (*Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1*)-ний харьяат болох хүсэлтийг түдгэлзүүлсэн.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын 10 иргэн (*Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 10*)-ний хүсэлт, баримт бичигт холбогдох байгууллагуудаас санал авч, дүгнэлт үйлдэн Монгол Улсын Ерөнхий Сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, гадаадын 5 иргэн (*Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 3, харьяалалгүй 2 хүн*)-ний хүсэлт, холбогдох баримт

бичгийг хянан Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүллээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2016 оны А/65 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчтай ярилцлага хийх журам”-ын дагуу хүсэлт гаргасан гадаадын 7 иргэн (*Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 7*)-тэй ярилцлага хийсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 83, 84, 85, 86, 87, 88, 89 дүгээр, 05 дугаар сарын 17-ны өдрийн 98 дугаар зарлигаар нийт 145 иргэн бусад улсын харьяат болох (*Бүгд Найрамдах Австри Улсын 14, Бүгд Найрамдах Солонгос Улсын 47, Нидерландын Вант Улсын 1, Бүгд Найрамдах Сингапур Улсын 5, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын /Тайвань/ 1, Бүгд Найрамдах Казахстан Улсын 1, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 60, Япон Улсын харьяат болох 16*)-оор Монгол Улсын харьяатаас гарсан.


Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын харьяат болох хүсэлт гаргасан 11 иргэн (*Бүгд Найрамдах Австри Улсын 1, Бүгд Найрамдах Солонгос Улсын 3, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 5, Япон Улсын харьяат болох 2*)-ний баримт бичигт санал авахаар холбогдох байгууллагуудад, 17 иргэн (*Бүгд Найрамдах Австри Улсын 2, Бүгд Найрамдах Солонгос Улсын 6, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 7, Япон Улсын харьяат болох 2*)-ний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авч, дүгнэлт үйлдэн Ерөнхий Сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 31 иргэн (*Бүгд Найрамдах Австри Улсын 4, Бүгд Найрамдах Солонгос Улсын 17, Нидерландын Вант Улсын 2, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 4, Япон Улсын харьяат болох 4*)-ний хүсэлтийг хянан Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн тус тус хүргүүллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 96, 97 дугаар зарлигаар харьяалалгүй 19 хүн тус улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээх хүсэлт гаргасан харьяалалгүй 3 хүний хүсэлт, баримт бичигт санал авахаар холбогдох байгууллагуудад, харьяалалгүй 3 хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авч, дүгнэлт үйлдэн Ерөнхий Сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, харьяалалгүй 2 хүний баримт бичгийг хянан Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Дээрх хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 13 иргэнийг шинээр бүртгэж, бүртгэлийг мэдээллийн санд оруулсан. /Хүснэгт 2/

Хүснэгт 2



Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6.7 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын харьяатаас гарсан 145, иргэний

харьяаллаа сэргээн тогтоолгосон 19, нийт 164 иргэний мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор гадаадын иргэний нэгдсэн бүртгэлийн санд 51 улсын 3846 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна.

1.2.2. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах 8 байгууллагын хүсэлтийг хүлээн авч, Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн 1 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтэд санал авахаар холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 87 төрийн бус байгууллага бүртгэлтэй байна.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Тайлант хугацаанд 4 удаагийн төлөвлөгөөт, 10 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 27 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 79 иргэнийг хамруулснаас гадаадын 5 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 300,000 төгрөг (*Гурван зуун мянган*)-ийн шийтгэл оногдуулж, улсын төсөвт төвлөрүүллээ.

1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.11 дэх заалтыг үндэслэн 2 улсын 2 иргэн / *Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1, Оросын Холбооны Улсын 1*-ийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар албадан гаргасан. /Хүснэгт 3/

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 3 улсын 5 иргэн (*Бүгд Найрамдах Солонгос Улсын 2, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 2, Оросын Холбооны Улсын 1*) -ийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүллээ. /Хүснэгт 3/

Хүснэгт 3



2021 оны гуравдугаар сарын тоон үзүүлэлтийг 2020 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 91,2 хувиар буурч, зөрчил гаргасан уригч иргэн болон уригч хуулийн этгээд бүртгэгдээгүй байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг 05 дугаар сарын 13-ны өдрийн 01/676 дугаар албан бичгээр болон цахим хэлбэрээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын үйл ажиллагааны дөрөвдүгээр сарын тайланг нэгтгэн боловсруулж, 05 дугаар сарын 04-ний өдөр байгууллагын цахим хуудаст байршуулан, тоон мэдээг инфографик хэлбэрээр мөн өдрийн 01/632 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.

Байгууллагын 2021 оны тавдугаар сарын төлөвлөгөөг 05 дугаар сарын 01-ний өдөр баталж, дөрөвдүгээр сарын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг мөн сарын 02-ны өдөр гаргалаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнө авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 05 дугаар сарын 18-ны өдөр батлав.

2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц:

Тайлант хугацаанд төрийн захиргааны албан тушаалд 6, төрийн үйлчилгээний ажлын байранд 3 албан хаагч томилогдож, нэгж хооронд 1 албан хаагч шилжиж, 1 албан хаагч дэвшүүлэн томилогдсон, 2 албан хаагч чөлөөлөгдсөн байна. Мөн нийт 3 албан хаагчид “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу тусламж олгож ажиллалаа.

Гадаадын иргэн, харьяатын газрын сургалт, хүний нөөцийн хөгжлийн урт хугацааны (2021-2031) цогц бодлого, хөтөлбөрийг боловсруулах “Ажлын хэсэг”-ийг байгууллагын даргын 05 дугаар сарын 24-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар баталсан.

Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан төрийн дээд одон, медаль болон салбарын шагналд нэр дэвшүүлэх албан хаагчдын холбогдох материалыг 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/729 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.

2.1.3. Сургалт:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан уг хуулийг дагалдаж гарах журмуудыг албан хаагчид болон хамтран ажиллах байгууллагын зарим албан хаагчдад танилцуулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах нэгдсэн удирдамжийг байгууллагын даргын 05 дугаар сарын 25-ны өдрийн А/96 дугаар тушаалаар баталсан.

“Дархан-Энх Оршихуй” гадаад хэлний сургалтын төвтэй хамтран 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 28-ны өдрийг дуустал зохион байгуулсан англи хэлний анхан болон дунд шатны цахим хичээлд нийт 100 албан хаагч хамрагдлаа.

Гадаадын иргэн, харьяатын газарт шинээр томилогдсон албан хаагчдын мэдлэг, ур чадварын түвшинг тодорхойлох, байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт, онцлог, чиг үүргийг таниулах чиглүүлэх сургалтыг 05 дугаар сарын 17-ноос 27-ны өдрийн хооронд зохион байгуулж, төв болон бүс, орон нутагт шинээр томилогдсон 14 албан хаагчийг хамруулсан.

Албан хаагчдын баримт бичиг боловсруулах албан хэрэг хөтлөх чадамжийг дээшлүүлж, баримт бичиг боловсруулах, түүний хүчин төгөлдөр байдлыг хангах, албан хэрэг хөтлөлтөд тавигдах шаардлага хангах, баримт бичгийн найруулга зүйн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор архив албан хэрэг хөтлөлтийн сургалтад 10 албан хаагч 05 дугаар сарын 10, 12-ны өдрүүдэд үргэлжлүүлэн суралцсан.

Байгууллагын мэдээллийн цагт 05 дугаар сарын 28-ны өдөр “Харилцааны ёс зүй”, 21-ний өдөр “Төрийн албаны шинэчлэл, ёс зүйн хандлага” сэдвээр зохион байгуулагдсан сургалтад давхардсан тоогоор 82 албан хаагчийг танхимаар, орон нутаг дахь албан хаагчдыг цахим хэлбэрээр хамруулан ажиллалаа.

#### 2.1.4. Олон нийт, мэдээ, мэдээлэл:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой 7 мэдээ, 2 ярилцлагыг байгууллагын цахим хуудаст байршуулж, давхардсан тоогоор 54 хэвлэл мэдээллийн хэрэгсэл (12 телевиз, 4 сонин, 38 сайт)-ээр олон нийтэд хүргэв. Тухайлбал: Гадаадын иргэдийг сайн дурын үндсэн дээр вакцинд хамруулж байгаа талаарх мэдээ [mbn.mn](http://mbn.mn), [montsame.mn](http://montsame.mn), [ugluu.mn](http://ugluu.mn), [ergelt.mn](http://ergelt.mn) зэрэг 8 сайтад тавигдаж, 05 дугаар сарын 05-ны өдөр МҮОНТ-ээр цацагдсан. Мөн шуудан хүргэлтийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг [ikon.mn](http://ikon.mn), [mnb.mn](http://mnb.mn), [zindaa.mn](http://zindaa.mn), [montsame.mn](http://montsame.mn), [chuhal.mn](http://chuhal.mn), [assa.mn](http://assa.mn), [unen.mn](http://unen.mn) зэрэг 11 сайтад нийтлүүлж, англи, орос, хятад, солонгос хэлээр бэлтгэн, олон нийтэд мэдээлсэн.

Байгууллагын дарга Н.Ууганбаяр 05 дугаар сарын 19-ний өдөр UBS телевизийн "Нүүр тулсан ярилцлага", 05 дугаар сарын 05-ны өдөр Bloomberg телевизийн “Ярилцах цаг” нэвтрүүлэгт тус тус оролцож, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгснийг “Монголын үнэн” сонины 05 дугаар сарын 10-ны өдрийн дугаарт нийтлүүлж, [gogo.mn](http://gogo.mn), [eagle.mn](http://eagle.mn), [zindaa.mn](http://zindaa.mn), [24tsag.mn](http://24tsag.mn), [newspress.mn](http://newspress.mn), [zogii.mn](http://zogii.mn) зэрэг 10 сайтад байршууллаа. Түүнчлэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, онцлог зохицуулалтын талаар МҮОНТ-ийн “Цагийн хүрд” хөтөлбөр, ТВ8 телевизийн мэдээллийн хөтөлбөрт тус тус ярилцлага, мэдээлэл өгсөн.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар танилцуулах уулзалт, зөвлөгөөнийг гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газруудтай хамтран зохион байгуулж байгаа бөгөөд 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан БНСУ-ын ЭСЯ-ны уулзалт, зөвлөгөөнийг UBS, ТВ8 телевиз, [zindaa.mn](http://zindaa.mn), [montsame.mn](http://montsame.mn), [mnews.mn](http://mnews.mn) сайтаар, 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан БНСВУ-ын ЭСЯ-ны уулзалт, зөвлөгөөнийг [ontslokh.mn](http://ontslokh.mn), [zindaa.mn](http://zindaa.mn), [mnb.mn](http://mnb.mn) сайтаар сурталчилж олон нийтэд мэдээллээ.

Цахим төлбөрийн Гэрэгэ киоск машиныг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээг 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, тус үйл ажиллагааны талаарх мэдээллийг ТВ8, UBS телевиз, [zindaa.mn](http://zindaa.mn) сайтуудыг оролцуулж олон нийтэд хүргэсэн ба байгууллагын дарга Н.Ууганбаярын "Гэрэгэ киоск" систем ашиглан Гадаадын иргэн, харьяатын байгууллагын 66 төрлийн үйлчилгээг цахимаар авч, төлбөрөө төлөх боломжтой боллоо” гарчигтай ярилцлага өдөр тутмын “Өдрийн сонин”-ы 05 дугаар сарын 19-ний өдрийн дугаарт нийтлэгдэж, ярилцлагын мэдээллийг [24tsag.mn](http://24tsag.mn), [ontslokh.mn](http://ontslokh.mn), [zindaa.mn](http://zindaa.mn), [itoim.mn](http://itoim.mn) сайтуудад тус тус нийтлүүлсэн.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, зөвлөгөө бүхий нийт 51 мэдээлэл (зураг, постор, видео)-ийг байгууллагын цахим хуудаст

байршуулсан ба цахим хуудас 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 15,063 дагагчтай, хандалт дунджаар 40 мянга орчим байна.

Түүнчлэн байгууллагын твийтэр, инстаграмм хаягуудыг шинээр нээж, хөгжүүлэлт хийн, 16 мэдээлэл байршууллаа.

2.2: Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдал, эрүүл мэндийн чиглэлээр:

2.2.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй байдал:

Байгууллагын даргын “Гамшгаас хамгаалах шуурхай штабын бүлэг байгуулах тухай” А/92 дугаар тушаалыг баталлаа.

Улсын онцгой комиссын 2021 оны “Халдвар хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын мэдээг Улсын онцгой комисст цахим хаягаар хүргүүлсэн.

2.3. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

2.3.1. Хууль, эрх зүй:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг дагалдан гарах “Монгол Улсын виз олгох журам”-ын төсөл, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ын төсөл, “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын төсөл, “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22.2 дахь хэсэгт заасны дагуу “Нийтийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчний жагсаалт батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран батлах тушаалын төслийг боловсруулж, бусад байгууллагын саналыг тусган Хууль зүй, дотоод хэргийн яаманд 05 дугаар сарын 28-ны өдрийн 01/773 дугаар албан бичгээр хүргүүлэв.

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Үндэсний аюулгүй байдлын яамны харьяа Гадаадын иргэн, харьяатын газартай байгуулах “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн төслийг боловсруулж, 05 дугаар сарын 03-ны өдрийн 01/624 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулахаар хүргүүллээ.

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд, гадаадын иргэдэд хууль сурталчлах чиглэлээр хийж буй ажлын явц, хэрэгжилтийг 05 дугаар сарын 07-ны өдрийн 01/638 дугаар албан бичгээр Нийслэлийн прокурорын газарт тус тус хүргүүлсэн.

2.3.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Ижил чиг үүргийн байгууллагуудын шинэ мэдээ, мэдээллийг “7 хоногийн тойм” нэрээр бэлтгэн долоо хоног тутам Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, хамтын ажиллагааны газарт цахим хэлбэрээр хүргүүлэн ажиллаж байна.

Гэрэгэ Системс киоск төхөөрөмжийн үйлдлийн системийн мэдээллийг англи, орос, солонгос, хятад хэл рүү, “Хилийн аюулгүй байдлын нэгдсэн систем”-ийн танилцуулгыг англиас монгол хэлнээ тус тус хөрвүүлээ.

Мөн “KGB Tegbe” хүргэлтийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа талаарх мэдээллийг орос, англи, хятад хэл рүү хөрвүүлэн байгууллагын албан ёсны вебсайт, цахим хуудаст байршуулсан.

2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр АНУ-ын Элчин сайдын яамны Бүс нутгийн аюулгүй байдлын атташег хүлээн авч харилцаа, хамтын ажиллагааны талаар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын даргатай хил орчмын аялал жуулчлалтай холбогдуулан тус тус уулзалт хийв.

2021 оны 05 дугаар сарын 19-ний өдөр БНХАУ-ын Элчин сайдын яам болон Монгол дахь хөрөнгө оруулагчдын Зун Хуа нийгэмлэгтэй хамтран Монгол Улсад оршин суугаа БНХАУ-ын хөрөнгө оруулагчид, иргэдэд “Шинэчлэн батлагдсан гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн танилцуулга уулзалт, зөвлөгөөн” сэдэвт 2 цагийн арга хэмжээг зохион байгуулав.

2021 оны 05 дугаар сарын 19-ний өдөр байгууллагын дарга Н.Ууганбаяр албаны хүмүүсийг хүлээн авч, Зун Хуа нийгэмлэгийн гүйцэтгэх захиралтай хамтын ажиллагааны талаар, Монгол-Хятадын соёл, бизнесийг дэмжих холбооны төлөөлөгч, Эрээн хотын олон улсын худалдааг дэмжих холбооны Монгол Улс дахь төлөөлөгчтэй нэг өдрийн аялал жуулчлал болон визийн төлбөрийн талаар санал солилцов. Мөн өдөр Баяннуурын бизнесийн холбооны уул уурхайн худалдан авалт хариуцсан компанийн дэд тэргүүнтэй уулзалт зохион байгууллаа.

2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр байгууллагын дарга Н.Ууганбаяр БНСУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга, ахлах ажилтан, БНСУ-аас Монгол Улсад суугаа иргэдийн нийгэмлэгийн тэргүүн зэрэг албаны хүмүүс, мөн 27-ны өдөр БНСВУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдтай тус тус уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Тус байгууллагын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ч.Алтансүх 05 дугаар сарын 10-ны өдөр АНУ-ын Элчин сайдын яамны Бүс нутгийн аюулгүй байдлын атташе, албаны бусад хүмүүсийг хүлээн авч харилцаа, хамтын ажиллагааны талаар уулзалт хийлээ.

2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Тайлант хугацаанд 2 албан хаагчид 16 хадгаламжийн нэгж ашиглалтад олгож, 14 албан хаагчид 258 хуудас баримтыг “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж, хуулбарлан өгсөн.

2020 оны баримт бичгийг архивд хүлээн авах ажлын хүрээнд 2 албан хаагчаас 87 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, сан хөмрөгийн бүрдүүлэлт хийж ажиллав.

Байгууллагад ирүүлсэн нийт 231 албан бичиг (*хариутай 58*)-ээс 9 албан бичиг шийдвэрлэх шатандаа байгаа бөгөөд 213 албан бичгийг гадагш илгээсэн. Байгууллагын даргын баталсан 37 тушаал /*А тушаал 15, Б тушаал 22*-ыг бүртгэж, цахим хэлбэрт шилжүүлэн ажиллалаа.

2.4.2. Өргөдөл, гомдлын чиглэлээр:

2021 оны тавдугаар сард аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан хаагчдаас 30 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, 22 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 8 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна. Хуулийн хугацаа хэтрүүлсэн өргөдөл байхгүй.



## 2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

### 2.5.1: Программ хангамж:

eVisa.gov.mn домэйн нэр дээр email хаяг үүсгэх боломжтой болгож, өмнө авсан визийг дахин авах хөгжүүлэлтийг хийсэн.

Цахим хуудсын шинэчилсэн хувилбарын UI дизайныг Некст дизайн ХХК-иас 05 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авч, программ хангамжийн хөгжүүлэлтийг эхлүүлээд байна.

Цахим визийн мэдээллийн санг хөгжүүлэгч Интерактив ХХК-д ISM системийн хэрэглэгчийн гарын авлага, мэдээллийн сангийн drt файл, өгөгдлийн сангийн ERD бүтцийг хүлээлгэн өглөө.

ISM системийн шинэчилсэн хувилбар болох 1.0.2.1-ийг 2021 оны 05 дугаар сарын 10-наас 19-ний өдрийн хооронд хяналтын улсын байцаагчийн нийт 8 компьютерт суулгаж, бүс, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын ism болон spark програмын нийт 26 удаагийн эрхийг шилжүүлсэн.

Төрийн мэдээлэл солилцооны ХУР, ДАН системийн гэрээг шинэчлэн байгуулав.

## 2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

### 2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

2021 оны 05 дугаар сард өссөн дүнгээр 1,703.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,244.6 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлэн, журналын бичилтийг тухай бүр бүртгэж ажилласан.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-т заасны дагуу Монгол улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хязгаарт тусгах саналыг өгөхтэй холбоотойгоор төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/740 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Мөн 06 дугаар сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн, Хууль зүй дотоод хэргийн яаманд 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/741 дүгээр албан бичгээр хүргүүлээ.

### 2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр 402.3 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж, 9.0 сая төгрөгийн хүү, торгуулийн орлого төвлөрүүлж, Хан-Уул дүүргийн татварын орлогын дансанд шилжүүлсэн.

### 2.6.3. Хангалт, худалдан авалт:

Мэдээлэл технологийн үйлчилгээний 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/07-04 дүгээр гэрээ дүгнэсэн актаар Голден Хоул ХХК-иас гэрээнд тусгагдсан лицензийн худалдан авалтын нийлүүлэлт хийгдлээ.

## 2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

### 2.7.1. Хяналт-шинжилгээ:

Байгууллагын 2021 оны 05 дугаар сард хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх Ж.Энхбаяр, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 01/631, 01/629, 01/630 дугаар албан бичгээр, 2021 оны 05 дугаар сарын гадаадын иргэний бүртгэл, хяналтын танилцуулах тойм мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны

Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газарт 01/628 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэн ажиллав.

Байгууллагын 04 дүгээр сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт 74.1 хувьтай байна.

Байгууллагын 2020 оны төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээнд хяналт-шинжилгээ хийж, 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр тайлагнасан.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтран хэрэгжүүлэх 2021 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу холбогдох ажил, арга хэмжээний 05 дугаар сарын биелэлтийг нэгтгэн гаргав.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт байгууллагын үндсэн үйл ажиллагааны нийт 20 удаагийн мэдээг 05 дугаар сарын 03-наас 31-ний өдрүүдэд цахим хэлбэрээр өгч ажиллалаа.

Төв, орон нутаг дахь газруудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 05 дугаар сарын байдлаар хяналт тавин ажиллаж, байгууллагын нэгдүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийлээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан виз, зөвшөөрлийн чиглэлээр хүчин төгөлдөр үйлчилж буй Хууль зүй, дотоод хэргийн сайдын болон байгууллагын даргын баталсан тушаал шийдвэрт Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хяналт-шинжилгээ хийсэн.

#### 2.8. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

“Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх журам”-ын төсөлд өгөх саналыг 05 дугаар сарын 13-ны өдрийн 01/677 дугаар албан бичгээр Улсын онцгой комисст, Монгол Улсын хил хааснаас хойш тус улсын хилээр нэвтэрсэн гадаадын иргэдийн талаарх судалгааг 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/768 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд тус тус хүргүүлсэн.

Цагаандэл-Уул хилийн боомтын төлөвлөлтийн асуудлаар 05 дугаар сарын 13-ны өдрийн цахим хурлын шийдвэрийн дагуу тус боомтыг түр горимоор нээн ажиллуулахад манай байгууллагад шаардагдах зардлын тооцоог гарган 05 дугаар сарын 17-ны өдрийн 03/699 дугаар албан бичгээр Гаалийн ерөнхий газрын Боомтын хөгжлийн хэлтэст хүргүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын Баруун бүсэд хийх айлчлалтай холбогдуулан холбогдох орон нутаг дахь нэгжүүдийн танилцуулгыг 05 дугаар сарын 13-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар хүргүүлж ажиллалаа.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР